



ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Отгонтэнгэр их сургуулийн Эдийн засаг, бизнесийн удирдлагын сургууль

Хөтөлбөрийн нэр: “Нягтлан бодох бүртгэл” бакалавр

Индекс: D041101

Шинжээчийн баг:

Ахлагч: Л.Энх-Амгалан

Гишүүд: Н.Нямаа

М.Уранчимэг

2020. 05. 28

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

АНУ	Америкийн нэгдсэн улс
АХБ	Азийн хөгжлийн банк
АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БЗД	Баянзүрх дүүрэг
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
МИС	Мандах их сургууль
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
МУИС-БС	Монгол Улсын их сургуулийн Бизнесийн сургууль
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
ОТИС	Отгонтэнгэр их сургууль
ОНӨААТҮГ	Олон нийтийн өмчит аж ахуйн төрийн үйлчилгээний газар
СЭЗИС	Санхүү эдийн засгийн их сургууль
ТМЗ	Татварын мэргэшсэн зөвлөх
ТББ	Төрийн бус байгууллага
УБ	Улаанбаатар
УБТЗ	Улаанбаатар төмөр зам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ЭЗБС	Эдийн засаг, бизнесийн сургууль
ЭЗБУС	Эдийн засаг, бизнесийн удирдлагын сургууль
ЭШХ	Эрдэм шинжилгээний хурал
ACBSP	Accreditation Council for Business Schools and Programs
IF	Impact Factor
ISO	International Organization for Standardization
SWOT	Strengths, Weaknesses, Opportunities, and Threats
TOWS	Threats, Opportunities, Weaknesses and Strengths

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Отгонтэнгэр Их сургуулийн Эдийн засаг, бизнесийн удирдлагын сургууль Otgontenger University	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Нягтлан бодох бүртгэл бакалаврын хөтөлбөр Bachelor of Accounting	
Индекс	D041101	
Шинжээчид	<p>Ахлагч: Л.Энх-Амгалан- Мандах их сургуулийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал</p> <p>Гишүүд: Н.Нямаа- ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн профессор</p> <p>М.Уранчимэг - Сангийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын Нягтлан бодогч</p>	
БМИҮЗ-ийн зохицуулагч	П.Оргилмаа – БМИҮЗ-ийн магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	5/20	Шинжээчийн багийн бүрэлдэхүүнийг танилцуулах, Шинжээч ажиллах хуваарь, хөндлөнгийн үнэлгээний талаар танилцуулах, Өөрийн үнэлгээний үйл ажиллагаа, хөтөлбөрийн танилцуулга хийх
	5/20	Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцах, өөрийн үнэлгээний багийн гишүүнтэй уулзах,
	5/20	Хөтөлбөрт хамаарах багш, ажилтнуудтай уулзах
	5/21	Оюутнуудтай хийх уулзалт
	5/21	Төгсөгчдийн төлөөлөлтэй хийх уулзалт
	5/21	Ажил олгогчдын төлөөлөлтэй хийх уулзалт
	5/21	Шинжээчийн баг урьдчилсан дүгнэлтээ танилцуулах
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан “Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам, магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагын дагуу ажиллав.	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Холбогдох хууль, эрх зүйн актууд, сургуулийн стратеги төлөвлөгөө, алсын хараа, эрхэм зорилго, зорилтуудад нийцүүлэн Нягтлан бодох бүртгэлийн бакалаврын хөтөлбөрийг боловсруулсан. Сургалтын хөтөлбөрийг 2012, 2014, 2017 онуудад шинэчлэн боловсруулж, агуулгыг сайжруулан, тус хөтөлбөрөөр 21 дэх жилдээ сургалтын үйл ажиллагаа явуулан мэргэжилтэн бэлтгэж байна. 2014 онд уг хөтөлбөрийг эхний удаа магадлан итгэмжлүүлсэн. Энэ он буюу 2020 онд 2 дахь удаагаа магадлан итгэмжлүүлэх гэж байна.

Нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрийн зорилго нь олон улсын их, дээд сургуулиудын жишигт нийцэхүйц нягтлан бодох бүртгэлийн өргөн мэдлэгтэй, аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн мэдээллийг боловсруулан дүн шинжилгээ хийж, тайлагнах чадвартай, ёс зүйтэй мэргэжилтэн бэлтгэхэд оршиж байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн А/78 тоот тушаал, 2014 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн А/174 тоот тушаал
- Нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрт хийсэн чиг хандлагын шинжилгээ
- Хөтөлбөрийг гадаад, дотоодын их сургуулиудын хөтөлбөртэй харьцуулсан судалгаа
- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж,

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Дэлхийн болон өөрийн орны сургалтын технологийн шинэ чиг хандлага, мэдээллийн технологийн шаардлагад нийцүүлэн, хувь хүний харилцааны чадвар, хандлагыг хөгжүүлэхэд анхаарсан.

- Гадаад, дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулж хөтөлбөрөө боловсруулсан.
- Нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрт чиг хандлагын шинжилгээ хийдэг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн төлөвлөлтөд нийгэм, хүн ам зүй, эдийн засаг, технологи, байгаль орчин, улс төр, хууль эрх зүйн нөлөөллийн талаар хийсэн шинжилгээний үр дүнг тусгах талаар анхаарах.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн төлөвлөлтөд оролцогч талуудын санал, хүсэлтийг сайтар харгалзан үздэг байх.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- ОТИС-ийн стратеги, хөгжлийн зорилго, зорилтоо тодорхойлсон баримт бичгүүд
- ОТИС-ийн ЭЗБУС-ийн Алсын хараа, Эрхэм зорилго болон хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичгүүд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн зорилгоо тодорхойлохдоо мэргэжлийн мэдлэг, чадвар сайтай байхаас гадна ёс зүйтэй мэргэжилтэн бэлтгэх талд их анхаарсан.
- Сургууль болон хөтөлбөрийн зорилго, зорилтын нийцэл, уялдаа холбоог зорилго, зорилт бүрээр тодорхойлж гаргасан.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн зорилго, зорилтоо тодорхойлохдоо ажил олгогчийн саналыг авч, харгалзаж үздэг байх.

Зөвлөмж:

- Гадаад, дотоодын мэргэжлийн байгууллагуудын гаргаж буй зөвлөмжийг судлан хөтөлбөрийн зорилгоо тодорхойлохдоо харгалзаж үзэх.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрүүд
- Сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явцын зураглал

- Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааны зохион байгуулалт
- Нягтлан бодох бүртгэл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн судалгаа
- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүдийг салбарын болон байгууллагын эрх зүйн хүрээнд шаардлагын дагуу бүрэн боловсруулсан.
- Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар судалгаа авдаг.
- Хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүнд Нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрийн дэд хороо ажилладаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн төлөвлөлтөд хийсэн SWOT, TOWS шинжилгээний үр дүнг хөтөлбөрийн үйл ажиллагааг сайжруулахад сайтар ашигладаг байх.

Зөвлөмж:

- Нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрийн дэд хорооны үйл ажиллагааг сайжруулах

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр
- Сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явцын зураглал
- Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааны зохион байгуулалт
- Нягтлан бодох бүртгэл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн судалгаа
- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын агуулга нь тавигдаж буй шаардлагыг хангаж байгаа бөгөөд энэ чиглэлээр суралцагчдаас судалгаа авч хэвшсэн, хөтөлбөрийн ерөнхий болон дэд хороодын үйл ажиллагаа төлөвшиж байгаа.
- Хичээлүүдээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй хэрхэн нийцэж буй байдлыг тодорхойлж харуулсан.

Анхаарах асуудал:

- Зааж буй хичээлүүдийн агуулга, амжилтад хүрэхүйц мэдлэг, ур чадвар олж авч чадаж байгаа эсэх, судалж буй хичээлүүд нь цаашид гүнзгийрүүлэн судлах хүсэл эрмэлзлэлийг бий болгож чаддаг эсэх талаарх судалгаануудад хариулсан оюутнуудын хариултыг сургалтын агуулгаа шинэчлэхдээ сайтар харгалзан үзэх.

Зөвлөмж:

- Сургалтын агуулгаа шинэчлэхдээ мэргэжлийн байгууллагуудын зөвлөмж, ажил олгогчдын саналыг харгалзан үзэх.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн А/78 тоот тушаал, 2014 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн А/174 тоот тушаал
- Нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрт хийсэн чиг хандлагын шинжилгээ
- ОТИС-ийн бакалаврын сургалтыг зохион байгуулахад баримтлах журам
- Сургуулийн багш, оюутны гарын авлага
- Сургуулийн цахим хуудас

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгодоо нийцсэн, сайжруулах чиглэлээр судалгаа авч ажилладаг.
- Суралцагч төвтэй, үр дүнд суурилсан сургалтын арга зүйг хэрэгжүүлж байна.
- Багш, оюутны хамтын ажиллагаа сайн.

Анхаарах асуудал:

- Оюутан багш, хичээлээ сонгох бололцоог бүрдүүлэх талаар анхаарч ажиллах.

Зөвлөмж:

- Өнөөгийн нөхцөл байдалд нийцүүлэн цахим сургалтыг амжилттай хэрэгжүүлж байна. Цаашид үүнийг улам бататган ажиллах.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- ОТИС-ийн бакалаврын сургалтыг зохион байгуулахад баримтлах журам
- Сургуулийн багш, оюутны гарын авлага
- Сургуулийн цахим хуудас

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх арга зүйтэй, түүнийг сайжруулах талаар анхаарч ажилладаг.

Анхаарах асуудал:

- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ хийх нэгдсэн шалгуурыг боловсруулах.

Зөвлөмж:

- Сургалтын үйл ажиллагааны хувьд сургуулийн давуу тал, бусдаас ялгарах онцлогийг нийтэд мэдээлж хүргэдэг байх.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл сайжруулалт хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори, төвүүд, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан.

- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалт явуулах анги танхим, лаборатори, багшийн ажиллах орчин зэрэг нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлага хангасан байна гэж үзэж байна.
- Салбар сургуулийн харьяанд 3 компьютерийн лабораторийн хүчин чадлыг сайжруулж бусад мэргэжлийн анги танхим, төвүүдийг орчин үеийн интерьер дизайнаар тохижуулж тоногловсон байна.
- Багш, оюутнуудын хүүхдийн “Одтой жаалууд” цэцэрлэгийн үйл ажиллагаа
- Сургалтын орчны сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийж хэвшсэн бөгөөд судалгааны үр дүн болон оюутнуудын сэтгэл ханамж өндөр байна.

Анхаарах асуудал:

- Материаллаг нөөцийг оновчтой хуваарилж бүрэн ашиглах, ашиглалтыг сайжруулах

Зөвлөмж :

- Сургалтын орчны давуу талыг илүү тодотгож өгөх

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Компьютерийн лаборатори, интерактив сургалтын төвд мэргэжлийн хичээлүүдийн сүүлийн үеийн програмуудыг (DIAMOND ERP 5.0, IMPACT, PAYROLL) албан ёсны эрхтэйгээр ашиглаж байна.

Анхаарах асуудал:

- Компьютер техник хэрэгслийн хүчин чадлыг сайжруулахад анхаарах

Зөвлөмж :

- Багш нарын заадаг хичээлийн ном, гарын авлагуудыг нэмэгдүүлэх

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа.
- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа, ном ашиглалтыг сайжруулах арга хэмжээ, ном сурталчлах арга хэмжээ
- Хөтөлбөртэй холбоотой сурах бичгийн жагсаалт, тэнхимийн дэргэдэх номын фонд
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 3600 орчим үндсэн сурах бичиг, гарын авлага, үзүүлэн таниулах материал, эрдэм шинжилгээний бичиг, семинарын хичээлийн дасгал ажил, хууль тогтоомжийн эмхэтгэл байна.
- Хөтөлбөртэй холбоотой 969 ном электрон санд фондын болон уншлагын гэсэн хэлбэрээр оюутнуудад үйлчилж байна. Мөн олон улсын онлайн эрхийг авч ашиглаж байна.
- Хөтөлбөрөөр суралцагсдад зориулан сүүлийн 5 жилийн байдлаар нийтдээ 808 нэр төрлийн 4248 ширхэг номыг 94,1 сая төгрөгөөр худалдан авсан, 3499 нэр төрлийн 8200 ширхэг 67,7 сая төгрөгийн номыг хандив тусламжаар, 47 нэр төрлийн 225 ширхэг 2,1 сая төгрөгөөр хэвлэмэл бус материалыг худалдан авсан нь санхүүгийн баримтаар нотлогдож байна.
- Үндсэн сурах бичгийн баяжилтыг жил бүр тогтмол хийж, мэргэжлийн номыг сурталчлах булан ажиллуулдаг.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн чиглэлийн сурах бичиг, гарын авлагыг бичиж сургалтанд ашиглах

Зөвлөмж:

- Англи хэл болон бусад хэлний номын эргэлтийг сайжруулах
- Олон улсын эрдэм шинжилгээ судалгааны цахим сангуудыг нэмэгдүүлэх

3-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ОТИС-ийн стратеги, хөгжлийн зорилго, зорилтоо тодорхойлсон баримт бичгүүд
- ОТИС-ийн ЭЗБУС-ийн Алсын хараа, Эрхэм зорилго болон хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичгүүд
- Оролцогч талуудаас авсан судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн, нийгмийн хариуцлагатай, оролцогч, сонирхогч талуудын оролцоог ханган ажиллаж байна.
- ОТИС үйл ажиллагаандаа 56 дүрэм, журам боловсруулж батлан мөрдөн ажиллаж байна. Эдгээрийн 77 хувь нь 2012 – 2017 онд шинэчлэгдэн батлагдсан.
- Дотоод хяналт шалгалт, үнэлгээний алба ажиллаж, сургуулийн үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх чиглэлээр оюутнуудаас санал асуулга, судалгаа авч хэвшсэн. Санал асуулга, судалгааны үр дүнгээр тодорхой ажлуудыг зохион байгуулж байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн удирдлагад оролцогч бүх талуудын оролцоог хангах талд анхаарах.

Зөвлөмж:

- Удирдлагын эрх мэдэл хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжид илүүтэй төвлөрөх.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- ОТИС-ийн стратеги, хөгжлийн зорилго, зорилтоо тодорхойлсон баримт бичгүүд
- ОТИС-ийн ЭЗБУС-ийн Алсын хараа, Эрхэм зорилго болон хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичгүүд
- Хамтын ажиллагаатай байгууллагуудтай байгуулсан гэрээ, санамж бичгийн хуулбар
- Хамтын ажиллагааны талаарх мэдээллүүд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Дотоод, гадаад хамтын ажиллагаа сайн хөгжсөн.
- БНСУ, Тайвань, АНУ, Англи, Швед, Бельги, Украин, БНХАУ, Япон зэрэг гадаадын их сургуулиудтай хамтран ажиллаж байна.

- Монголын Маркетингийн холбоо, ММНБИ, Монголын Менежментийн холбоо, Хүний нөөцийн институт зэрэг мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Төгсөгчидтэй тогтоосон эргэх холбоогоо сайжруулах.

Зөвлөмж:

- Ажил олгогч байгууллагуудтай нягт хамтран ажиллах.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- ЭЗБУС-ийн төлөвлөгөө, тайлан
- ЭЗБУС-ийн санхүүгийн төлөвлөгөө, тайлан
- ОТИС-ийн багш нарын үйл ажиллагаанд санхүүгийн хөшүүрэг хэрэглэх журам
- Урамшуулалт цалин олгох журам
- Багш, ажилчдад тэтгэмж тусламж үзүүлэх журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн орлогын тодорхой хувийг багш болон оюутны хөгжилд зарцуулж байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг санхүүжүүлэх бусад эх үүсвэрүүдийг судалж үзэх.

Зөвлөмж:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжид үйл ажиллагааны эрх мэдлээс гадна тодорхой хэмжээнд нэгжийн хамт олон мэдэж шийддэг байх санхүүгийн эрх мэдэл олгож болох юм.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- ОТИС-ийн стратеги, хөгжлийн зорилго, зорилтоо тодорхойлсон баримт бичгүүд
- ОТИС-ийн ЭЗБУС-ийн Алсын хараа, Эрхэм зорилго болон хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичгүүд
- Сургуулийн маркетингийн албаны ажлын төлөвлөгөө, ажлын тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ОТИС-д 3 хүний бүрэлдэхүүнтэй бие даасан маркетингийн алба ажиллаж байна. Энэ алба нь төрөл бүрийн арга хэрэгсэлээр тухайн хөтөлбөрийг сурталчилдаг.
- Мэргэжил сурталчлах өдөрлөг, уулзалт, хэлэлцүүлэг, спортын уулзалт, тэмцээнийг тогтмол зохион байгуулж байна.

Анхаарах асуудал:

- Маркетингийн идэвхжүүлэлтийн урт хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах.

Зөвлөмж:

- Цахим технологийг илүүтэй ашиглах.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- ОТИС-ийн бакалаврын сургалтыг зохион байгуулахад баримтлах журам
- Сургуулийн багш, оюутны гарын авлага
- Сургуулийн цахим хуудас
- Сургуулийн үйл ажиллагаа, элсэлтийн талаарх сурталчилгааны материалууд

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн талаарх мэдээллийг сургуулийн вэб хуудас, нийтийн мэдээллийн сүлжээ, өдөр тутмын сонин, телевизийн сувгуудыг ашиглан түгээдэг.

Анхаарах асуудал:

- Цахим хуудасдаа хөтөлбөрийн дэлгэрэнгүй танилцуулга, хөтөлбөрийн талаарх мэдээллийг цаг тухай бүрд нь шуурхай, тогтмол байршуулдаг байх.

Зөвлөмж:

- Нийтийн цахим сүлжээг ашиглан суралцагчид болон суралцахыг хүсэгчдэд шуурхай, оновчтой мэдээлэл хүргэх бололцоо байна.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, хэрэгцээ шаардлагад нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ОТИС-ийн дотоод дүрэм
- ОТИС-ийн оюутан элсүүлэх журам
- ОТИС-ийн жил бүрийн элсэлтийн комисс томилох тушаал
- Элсэгчдэд зориулсан гарын авлага, тараах материалууд
- Элсэгчдийн босго оноонд хийсэн судалгаа, дүгнэлт, тайлан
- Элсэгчдээс сургуульд орох болсон шалтгааныг тодруулах судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Жил бүр элсэлтийн журмыг шинэчлэн баталж, хэрэгжүүлдэг. 11 удаагийн элсэлтийн журам
- Тухайн жилд ажиллах элсэлтийн комиссыг байгуулж, элсэлтийн ажлыг зохион байгуулдаг.
- Элсэгчдийн бүртгэлийг интернет болон, сургууль дээр, орон нутагт гэсэн байдлаар гэсэн 3 хэлбэрээр зохион байгуулдаг.
- Сургуулийн талаарх мэдээллийг хэвлэмэл болон web хуудас, facebook ашиглан түгээхээс гадна, телевиз, радио, үзэсгэлэн яармагт оролцох байдлаар явагддаг.

Анхаарах асуудал:

- Элсэгчдийг тоог нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Элсэгчдэд зориулсан мэдээ, мэдээллийг тодорхой, агуулга сайтай болгох
- Элсэгчдийн элсэлтийн онооны дундаж үзүүлэлтийг нэмэгдүүлэх

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Эрдэм шинжилгээ судалгааны төвийн үйл ажиллагаа
- Career center төвийн үйл ажиллагаа
- Багш хөгжлийн төвийн үйл ажиллагаа
- Интерактив төвийн үйл ажиллагаа
- Нийгмийн судалгааны төвийн үйл ажиллагаа
- Ногоон оффис төвийн үйл ажиллагаа
- Оюутны бие даалтын төвийн үйл ажиллагаа
- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайлан
- Сэтгэл ханамжийн судалгаа, баримт материал
- Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайлан мэдээ.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан мэдээ
- Багш нарын ангитай ажилласан тайлангууд

- Шилдэг анги хамт олон шалгаруулах журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн удирдлагын баг, бүтэц зохион байгуулалт тус бүрээс ажил үүргийн хуваарилалтын дагуу оюутанд зөвлөх, тэднийг хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, график гаргаж үр дүнг тайлагнадаг.
- Оюутантай холбоотой дүрэм журмыг боловсруулж, мөрдөж ажилладаг.
- Сэтгэл ханамжийн судалгаа авч, түүний тайлан гаргаж, түүнтэй холбоотой ажлын төлөвлөгөө гаргаж ажилладаг.
- Олимпиад АСТ, уралдаан, тэмцээнд оюутнуудыг удирдаж оролцуулдаг.
- ЭЗБУС дээр 10 дугуйлан ажиллаж, оюутнуудад нээлттэй хичээллэдэг.
- Оюутныг хөдөлмөр эрхлэлт, цагийн ажилд зуучлах зорилготой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв байгуулагдан ажилладаг.
- Эрдэм шинжилгээ судалгааны төвтэй бөгөөд жил бүр төлөвлөгөө гаргаж, түүний дагуу ажиллаж тайлан гаргадаг.
- Шинээр докторын зэрэг хамгаалсан багш нар жил бүр эрдэмтний индэрт уригдаж, туршлагаа шинэ залуу багш, магистрант, докторантуудад танилцуулдаг.

Анхаарах асуудал:

- Зөвлөн туслах үйлчилгээний үйл ажиллагааг тогтмолжуулан сайжруулж, тэдгээртэй холбоотой тайлан мэдээ гаргаж, дүн шинжилгээ хийдэг болох

Зөвлөмж:

- Мэргэжлийн чиглэлээр цагийн ажил хийх нөхцөл бололцоог судлах

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Тогтвортой хөгжлийн боловсрол төслийн тайлан, мэдээ
- МОНО төслийн тайлан мэдээ
- Өнөөгийн нийслэлийн иргэдийн амьжиргааны төвшин судалгаа, тайлан
- Оюутнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн төлөвлөгөө, тайлан
- Олимпиадад оролцсон тухай тайлан, бэлтгэл ажлын төлөвлөгөө
- Олимпиад болон уралдаан тэмцээнд гаргасан амжилтууд
- АСТ, уралдаан тэмцээн зохион байгуулах, төлөвлөгөө, тайлан
- Оюутны холбооны ажлын төлөвлөгөө, тайлангууд
- ACBSP-ийн 8-р бүсийн хүрээнд зохион байгуулагдсан “Business simulation” тэмцээнд оролцсон байдал, үзүүлсэн амжилт
- Анги сурталчлах ажлын тайлангууд
- Мэргэжил сурталчлах ажлын тайлангууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ОТИС-ийн үүсгэн байгуулагчийн нэрэмжит тэтгэлэг, төгсөгчийн нэрэмжит тэтгэлэг олгодог.
- Үндэсний болон урамшуулалт тэтгэлэгт хамруулах
- Төрийн болон төрийн бус байгууллага, сан, банк санхүүгийн байгууллагаас зарласан тэтгэлэгт оролцоход нь дэмжлэг үзүүлэх
- Улсын болон бусад байгууллагаас олгодог тэтгэлэгт оюутнуудаа тодорхойлж, аль болох олон оюутнуудыг хамруулахыг зорьдог.
- “Тогтвортой хөгжлийг дэмжих 2030 клуб” ажилладаг.
- Моно төслүүдийг санаачлан хэрэгжүүлдэг.
- Шилдэг судлаач, шилдэг удирдагч, шилдэг анги хамт олон жил бүр шалгаруулж, алдаршуулдаг.

Анхаарах асуудал:

- Оюутнуудыг олон нийтийн ажилд аль болох жигд оролцуулах, тэтгэлэгт хөтөлбөрт оролцоход нь дэмжлэг үзүүлдэг байх

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- ОТИС-ийн дүрэм
- ОТИС-ийн бакалаврын сургалтын журам
- ОТИС-д оюутан шилжүүлэн суралцуулах журам
- Дахин шалгалт өгөх, хичээлийг дахин судлах, нэмэлт багц цаг цуглуулах журам
- Оюутны оюутны шилжилт хөдөлгөөнийг дээрх дүрэм, журмын хүрээнд зохицуулагддаг бөгөөд оюутны чөлөөнөөс ирж үргэлжлүүлэн суралцаж байгаа тухай сургуулийн Захирлын тушаал гардаг. Үүнд:
Суралцагч оюутныг сургуулиас чөлөөлөх, хасах асуудлыг ОТИС-ийн бакалаврын сургалтын журамд заасныг үндэслэн шийдвэрлэдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, кредит дүйцүүлэн тооцох журмыг баримтлан ажилладаг.
- Оюутнуудын шилжих санал хүсэл, өргөдлийг хүлээн авч, зохих журмын дагуу шийдвэрлэдэг.
- Жил бүрийн эцэст шилжилт хөдөлгөөний тайлан гаргаж, шилжих болсон шалтгааныг тодруулж авч хэлэлцдэг
- Шилжин ирсэн оюутны судалсан кредитыг хүлээн зөвшөөрч, судлаагүй хичээлийг нөхөн судлах боломжийг олгодог.

Анхаарах асуудал:

- Оюутнуудын шилжих болсон шалтгааныг судалгаанд анализ хийн, тогтвортой суралцах боломжийг сайжруулах

Зөвлөмж:

- Оюутнуудад чиглэсэн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөлтийн шалгалтын төв болон салбар комисс томилох захирлын тушаал
- Төгсөгчийн ажил эрхлэлтийн тушаал
- Төгсөгчдийг мөшгөх судалгаа
- Төгсөлтийн дипломын ажилд тавигдах шаардлага, стандарт
- Төгсөгчдийн товч анкет
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагаа, төлөвлөгөө тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Жил бүр төгсөлтийн шалгалтын комиссыг байгуулж, шалгалт өгөх эсвэл диплом бичиж хамгаалах боломжийг сонгох боломжтой.
- Төгсөлтийн дипломын ажилд тавигдах шаардлага, стандартыг гаргаж мөрддөг.
- Төгсөлтийн шалтгалтыг бичгээр болон амаар гэсэн 2 хэлбэрээр авах бөгөөд шалгалтын материалыг жил бүр шинэчлэн боловсруулдаг.

Анхаарах асуудал:

- Оюутнуудыг аль болох судалгааны ажил бичиж хамгаалуулах боломжийг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Мэргэжлээрээ ажиллах төгсөгчдийн тоог нэмэгдүүлэх

5-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- ОТИС-ийн багш нарын эрдэм шинжилгээний ажил, бэлтгэлийг урамшуулах журам
- ОТИС-ийн багш нарын үйл ажиллагаанд санхүүгийн хөшүүрэг хэрэглэх журам
- Урамшуулалт цалин олгох журам
- Багш, ажилчдад тэтгэмж тусламж үзүүлэх журам
- Сургуулийн цахим хуудас

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нар тогтвор суурьшилтай ажилладаг. Нийт багш, ажилтнуудын 75% нь 5-17 жил ажиллаж байна. Сүүлийн 5 жилд сургуулиас гарсан багш байхгүй. Эвсэг хамт олон бүрдсэн.
- Доктор зэрэгтэй багшийн эзлэх хувийн жин өсч байгаа ба сүүлийн 5 жилийн дунджаар 38.1% хувь нь доктор зэрэгтэй. Ойрын хугацаанд докторын зэрэг хамгаалахаар бүтээлээ бичиж, урьдчилсан хамгаалалтаас өмнөх хэлэлцүүлэгт орсон 2 багш байна.
- Эрдмийн зэрэг цолтой багш нарын тоог нэмэгдүүлэх урамшууллын тогтолцоог бий болгосон. Докторын зэрэг хамгаалсан багшид 3.0 сая төгрөгийн урамшуулал олгодог.
- ОТИС-ийн ЭЗБУС-ийн нийт багш нарын 11.7 хувь нь дадлагажигч багш, 11.9 хувь нь багш, 64.7 хувь нь ахлах багш, 11.7 хувь нь дэд профессорын орон тоон дээр ажиллаж байна.
- Багш суралцагчдын тооны зохистой харьцааны судалгааг хийсэн бөгөөд уг харьцаа зохистой хэмжээнд байна. Нэг багшид 12-13 оюутан ногдож байна.
- Гадаадаас багш нарыг урьж ажиллуулдаг. Эдгээр гадаад багш нарыг урьж ажиллуулснаар багш, оюутны мэргэжлийн мэдлэг болон англи хэлний мэдлэг дээшлэхэд хувь нэмэр оруулж байна. 2014-2019 онд нийт 14 багшийг ажиллуулжээ.
- Багшийн нөөцийн сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод зарлан сонгон шалгаруулдаг тогтолцоотой. Багш шинээр сонгон шалгаруулж авахдаа Бүтцийн сургуулийн захирал, Хүний нөөцийн менежер, Хөтөлбөрийн багийн гишүүн оролцдог буюу хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хамт олон санал өгдөг.
- 2018-2019 оны хичээлийн жилд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар А 319.1 кр, Б цаг 313.03 кр гүйцэтгэсэн бөгөөд нэг багшийн гүйцэтгэсэн дундаж цаг 19.8 кр байгаа нь багш нар танхмийн бус цагт судалгаа, шинжилгээний ажил хийх боломжийг бүрдүүлжээ.
- Багш, ажилтны цалин хөлсийг 2011 оноос хойш дунджаар 13.9%-аар нэмэгдүүлж байгаад 2019 онд нийт багш нарын цалин хөлсийг 10%-иар нэмэгдүүлсэн. Багш, ажилтнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдэх асуудлыг анхаарч авч үздэг. Багш нарт олгосон урамшууллын судалгааг хийсэн.
- Сургуулийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөнд эрдэмтдийн мэдлэг бүтээл, дамжуулах үйл ажиллагааг эдийн засгийн механизмаар дэмжин инновацийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх зорилтыг тусгасан.

Анхаарах асуудал:

- НББ-ын багш нар дунджаар 3-4 төрлийн хичээл зааж байгаа тул цаашид нэг багш 3-аас доош хичээл заахаар төлөвлөх, нэг багшид ногдох хичээлийн тоог нэмэгдүүлэхгүй байхад анхаарах
- Профессорын орон тоон дээр ажиллаж буй багш байхгүй байгаа тул уг орон тоонд ажиллах багшийг бэлтгэх

Зөвлөмж:

- Нэг багш 3-аас доош төрлийн хичээл заахад анхаарах.
- Доктор зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлэх
- Мэргэшсэн нягтлан бодогч зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлэх

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хүний нөөцийн Och HCM програм
- Хүний хөгжлийн цогц бодлого
- Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл-2019
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч сургуулийн эрдэм шинжилгээний ажлын төсөв, зардлын тооцоо
- “Багшлах боловсон хүчний өнөөгийн байдал, цаашдын зорилт”, сургуулийн захирлын илтгэл
- Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр
- “Багшийн хөгжлийн төв”-ийн хийсэн ажлын тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хүний нөөцийн Och HCM програмыг хүний нөөцдөө ашиглаж ирсэн.
- 2018 онд ОТИС нь 2018-2022 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх “Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр” боловсруулан мөрдөж байна. Энэ ажлын хүрээнд “Багшийн хөгжлийн төв”-тэй болсон.
- 2019-2020 оны хичээлийн жилийг “Багшийн хөгжлийн жил” болгон зарласан. Багш нарт англи хэлний хичээл заах хөтөлбөрийг 3 дахь жилдээ хэрэгжүүлж байна. Энэ нь EAP академик түвшиний англи хэлний сургалт бөгөөд багш нарын сургалтын төлбөрийн 50 хувийг сургуулиас, 50 хувь багш өөрөө төлдөг. Жилд 1 багш 500.0 мянган төгрөгийг сургалтын төлбөрт төлдөг. Багш нар уг хөтөлбөрт 2 жил хамрагдсны дараа хамгийн багадаа IELTS 5.5 оноо авах англи хэлний мэдлэгтэй болдог. Уг хөтөлбөрийг АРТОН \Олон улсын боловсролын институт\-ээс Монголд анх удаагаа ОТИС-тай хамтарч хэрэгжүүлж байна. Уг байгууллагаас сурах бичгийг нийлүүлдэг, мөн олон улсын шалгалтын өгөх төлбөрийг төлдөг. Харин хичээл заадаг багшийн төлбөрийг ОТИС даадаг.
- Багш нар үзүүлэх хичээл, нээлттэй хичээлийг тогтмол зохион байгуулдаг.
- Багш нарт зориулсан сургалтуудыг ажлын байран дээр нь зохион байгуулдаг. OJT (Ажлын байрандаа хөгжих-On the Job Training) хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

- “Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-т тусгагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу багш нар сургалтад хамрагдсан. ОТИС-ийн багшийн чадамжийн загварт зааснаар чадамжаа үнэлүүлэх үнэлгээний тогтолцоо хэрэгжиж эхэлсэн байна.
- Дээд боловсролын хөгжлийн академиас Сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх, багшийн сурган, заах арга зүйг сайжруулах чиглэлээр сургалт зохион байгуулсан.
- Багш нарт зориулсан төрөл бүрийн урамшуулал, дэмжлэгийг олгодог. Тухайлбал, 3 жилээс дээш ажиллаж байгаа багш, ажилтны хүүхдийг 4 жилийн сургалтын төлбөрөөс 100% чөлөөлөх, 3 жилээс дээш ажиллаж байгаа багш, ажилтны 2 дахь хүүхдийг 4 жилийн сургалтын төлбөрөөс 50% чөлөөлөх, Цэцэрлэгт хүмүүжиж байгаа хүүхдийн сарын төлбөрийг 50% хөнгөлөх гэх мэт.
- Багш, ажилчдын хүүхдэд зориулсан цэцэрлэгийн үйл ажиллагаа нь тогтмолгоод 6 дэх жилдээ ажиллаж байна.
- Гадаадад мэргэжил дээшлүүлсэн багшийн тоо цөөн байна. Тухайлбал, нэг багш 2020 онд Турк улсад богино хугацааны сургалтанд, багш Ганбат нь АНУ-д магистрын зэрэг хамгаалснаас өөр гадаад улсад мэргэжил дээшлүүлсэн багш байхгүй байна. Харин ACBSP бүсийн хуралд 2 багш оролцсон.
- Erasmus+ төслийн Arrow хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан сургалтанд 2019 онд 2 багш хамрагдсан ба уг сургалтанд тус сургуулиас нийтдээ 5 багш хамрагдсан.
- ОТИС-ийн Стратеги төлөвлөгөөний дунд шатны үнэлгээний тайланг бичиж цаашид багшийн хөгжлийн талаар хийх ажлыг төлөвлөжээ.

Анхаарах асуудал:

- Гадаад улсад урт, богино хугацааны сургалтанд хамрагдах багш нарын тоог нэмэгдүүлэхэд анхаарах.
- “Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн үнэлгээг хийж уг үнэлгээн дээр тулгуурлан дараагийн хөтөлбөрт хийх ажлыг төлөвлөх

Зөвлөмж:

- Багш нарын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажлууд хийгдэж байгаа ч тэдний англи хэлний мэдлэгийг гадаад улсад мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх түвшинд хүргэх
- ОТИС-ийн Гадаад харилцааны албанаас багш нарыг гадаад улсад мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх талаар мэдээллээр хангах, багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх замаар дэмжлэг үзүүлэх
- Багш нарыг гадаад улсын их, дээд сургуулиудын онлайн сургалтанд хамруулах

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- ЭЗБУС-ийн төлөвлөгөө, тайлан
- ЭЗБУС-ийн санхүүгийн төлөвлөгөө, тайлан
- ЭЗБУС-ийн Эрдэм шинжилгээний ажлын тайлан
- ЭЗБУС-ийн багш нарын бүтээлийн танилцуулга
- Багшийн ажлын хавтас

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Эрдэм шинжилгээний зардалд 2018 онд 14.3 сая төгрөг зарцуулсан. Уг зардалд ЭШХ зохион байгуулахад 1.2 сая төгрөг, Багш нарын ахисан түвшний сургалтын төлбөрийн хөнгөлөлтөнд 3.2 сая төгрөг, Багш нарын эрдэм шинжилгээний урамшуулалд 3.0 сая төгрөг, эрдэм шинжилгээний бичиг хэвлүүлэхэд 2.7 сая төгрөг, ном сурах бичиг худалдан авахад 4.2 сая төгрөг тус тус багтсан.
- Сургуулийн “Эрдэм шинжилгээ, судалгааны төв” нь мэдээллийн бааз бүрдүүлэх, сэтгүүл эрхлэн гаргах, сурах бичиг хэвлүүлэх, програм хангамжийг сайжруулах, магистрын ажлын мэдээллийн сан бүрдүүлэх, арга зүйн сургалт явуулах зэрэг ажлуудыг зохион байгуулжээ.
- “Нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлууд” ЭШБХ-ыг жил бүр зохион байгуулдаг нь багш нарын судалгааны бүтээлээ нийтлүүлэхэд үзүүлсэн чухал дэмжлэг болсон байна.
- “Be nice” АХБ-ны дээд боловсролын санхүүжилт, Career development” АХБ-ны дээд боловсролын санхүүжилт, ШХА-ын “Тогтвортой хөгжлийн боловсрол” гэсэн 3 томоохон төсөл хэрэгжсэн нь багш нарын судалгаа, шинжилгээний ажилд дэмжлэг болжээ.
- Багш нарын IF сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, TOEFL, IELTS шалгалт өгөх төлбөрийн 50 хувийг төлдөг.
- “Эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг 2019 оноос хэрэгжүүлж эхэлсэн ба уг хөтөлбөрийн хүрээнд “Эрдэм шинжилгээ, судалгааны төв”-ийг байгуулсан.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар сүүлийн 5 жилд 39 ном, гарын авлага, 71 эрдэм шинжилгээний өгүүлэл \үүнээс олон улсад 7 өгүүлэлийг олон улсын сэтгүүлд\ нийтлүүлсэн. Багш нарын эрдэм шинжилгээний бүтээлийн эшлэгдсэн тоо 6 ба үүнээс 1 нь англи хэл дээр, 1 нь орос хэл дээр хэвлүүлсэн бүтээл байна.
- Сүүлийн 5 жилийн хугацаанд 9 багш гадаад, дотоодын 28 төсөл, хөтөлбөрт оролцож судалгааны ажил хийжээ. Үүнээс 6 төсөл, хөтөлбөр нь ОТИС-ийн санхүүжилт болон захиалгаар гүйцэтгэсэн ажил байна.

Анхаарах асуудал:

- Багш нар IF-тай сэтгүүлд өгүүлэл нийтлүүлээгүй.
- Багш нар хянан магадлагаа хийгддэг олон улсын сэтгүүлд өгүүлэл нийтлүүлээгүй.
- Сүүлийн 5 жилд 28 төсөл, хөтөлбөрт оролцсон боловч эдгээр төслүүдэд багш нарын оролцоо жигд бус байна.

Зөвлөмж:

- Төсөл, хөтөлбөрт оролцдог туршлагатай багш нар залуу багш нарыг судалгааны ажилдаа оролцуулах, тэднийг судалгаа хийхэд дэмжлэг үзүүлэх
- Эрдмийн зэрэг, цолтой багш нь залуу багш нарыг дагалдуулж судалгааны ажлыг удирдах
- Багш нар багаараа хамтарч судалгааны ажлын санал бичиж захиалагч талд хүргүүлэх
- Багш нарын судалгааны ажилд зориулсан санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- ОТИС-ийн Хүний нөөцийн бодлогын баримт бичиг
- Сургалтын хэрэглэгдэхүүн, судалгааны ажилд тавих ерөнхий шаардлага CS110413:2018 стандарт
- Багш нарын хувийн хавтас, анкет
- Дотоод хяналт, шалгалтын талаарх тайлан, мэдээ
- Багшийн өөрийн үнэлгээний тайлангууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- ОТИС-ийн байгууллагын ISO9001:2015 хүрээнд сургалтын хэрэглэгдэхүүн, судалгааны ажилд тавих ерөнхий шаардлага CS110413:2018 стандартыг боловсруулсан.
- Багш өөрийн үнэлгээний тайлан бичиж багш өөрийн үйл ажиллагаандаа судалгаа хийдэг.
- Багшийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх тогтсон дүрэм, журамтай, үнэлгээг зохион байгуулах арга зүй нь хэвшсэн.
- Аттестатчлалын үр дүнд албан тушаалын зэрэглэл ахисан багш нарын тоо сүүлийн жилүүдэд өссөн.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш бүр хувийн хавтсыг анкет, сургалт судалгаа, мэргэжил боловсрол дээшлүүлсэн байдал, шагнал урамшуулал гэсэн хэсгүүдээр бүрдүүлэн, жил болгон баяжуулан ажилладаг.
- Багш бүр өөрийн үнэлгээний тайланг сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжил, нийгмийн үйл ажиллагаанд хийсэн ажлын гүйцэтгэлийн дагуу дүгнэж бичдэг.
- Оюутан социологийн судалгаагаар тухайн багшийн зааж байгаа хичээлд 16 үндсэн үзүүлэлтээр үнэлгээ өгч байсныг илүү дэлгэрэнгүй хувилбараар боловсруулсан байна. Энэ нь багшийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр цаашид зохион байгуулах ажлыг тодорхойлоход чухал нөлөөтэй байх боломжтой.

Анхаарах асуудал:

- Багшийн үнэлгээнд нийгмийн үйлчилгээ, олон нийтэд чиглэсэн, сайн дурын ажлыг үнэлэх тогтолцоог сайжруулах

Зөвлөмж:

- Багшийн үнэлгээнд эрдэм шинжилгээний ажлын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх. Багш нарын гадаад, дотоодын өндөр чансаатай сэтгүүлд бүтээлээ нийтлүүлэхэд шинжлэх ухааны өөр салбарын багш нартай хамтарч ажиллахад дэмжлэг үзүүлэх
- Багш нарын үндсэн ажлын цалингаас гадна судалгааны шинжилгээний ажлаас нэмэлт орлого олох боломжийг нээх үүднээс сургуулийн захиргаанаас шаардлагатай мэдээллээр байнга хангаж байх

6-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр
- Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт
- Сургуулийн жилийн ажлын төлөвлөгөө
- Бүтцийн сургуулиудын стратеги төлөвлөгөө
- Эрдэм шинжилгээ судалгааны ажлыг хөгжүүлэх хөтөлбөр
- Сургалтын чанарын хөтөлбөр
- Боловсрол судлалын докторын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг хангах төслийн тайлан
- Хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэл

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Чанарын менежментийн тогтолцооны ISO9001:2015 стандартын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дотоод аудитын сургалтад хамрагдсан 9 аудиторыг хамруулжээ.
- Хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтний орон тооны мэргэжилтэнтэй.
- Хөтөлбөрийн хороонд ажил олгогч 1, төгсөгчдийн төлөөлөл 1-ийг нь оруулж саналыг нь хөтөлбөрт тусгадаг. Хөтөлбөрийн хорооны хурлыг жилд жилд 2 удаа зохион байгуулдаг.
- ОТИС-ийн хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын гарын авлага, Багшийн хөгжлийн хөтөлбөр, Чанарын менежментийн тогтолцооны гарын авлага, ОТИС-ийн чанарын менежментийн тогтолцооны журмууд, ОТИС-ийн үйл явцын замын зураглал, холбоос, ОТИС-ийн мастер лист зэрэг стандарт, дүрэм, журам, гарын авлагыг боловсруулжээ.
- Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг сургалтын үйлчилгээ, багшийн үйл ажиллагаа, багш, ажилтнуудын сэтгэл ханамж, магистр, докторантуудын сэтгэл ханамжийн судалгаа гэсэн ялгаатайгаар буюу өргөн хүрээнд авч тайлан гарган холбогдох нэгж, тэнхимүүдэд танилцуулан үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа нь “Хөтөлбөрийн агуулга, уялдаа холбоо”, “Номын сангийн үйл ажиллагаа”, “Багшийн ур чадвар, харилцаа хандлага”, “Сургалтын орчин, нөхцөл”, “Интернэтийн үйл ажиллагаа”, “Бусад нэгжийн үйл ажиллагаа”, “Цайны газрын үйл ажиллагаа”, “Сургуульдаа үнэнч байдал”-г хамруулдаг.
- Багш нарын үйл ажиллагааны талаарх оюутны сэтгэл ханамжийн судалгаа /18 асуулгаар/, Багш, ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгаа /3 бүлэг 30 асуулттай/, Тэнхимийн эрхлэгчийн ажлын үнэлгээ, Захирлуудын ажлын үнэлгээ, Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, Ажил олгогч, төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааг жил бүр зохион байгуулдаг ба судалгааны хамрах хүрээ нь өргөн хүрээтэй байна.

Анхаарах асуудал:

- Оролцогч талуудаас хөтөлбөрийн талаар авсан судалгааны үр дүнд тулгуурлан хийсэн ажил, ахиц дэвшлийн талаар тайлан, танилцуулгыг тогтмол хийдэг байх

Зөвлөмж:

- Гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

- Чанарын зорилтуудын хэрэгжилтийн тайлан
- Чанарын менежментийн тогтолцооны хэрэгжилтийн тайлан
- Дотоод аудитын тайлан
- Удирдлагын дүн шинжилгээний тайлан
- Оюутнуудын сэтгэл ханамжийн судалгааны тайлан
- Багш нарын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааны тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдийн ажил эрхлэлт болон ажлын байрны нийцлийн судалгааг жил бүрийн 6 ба 12 сард буюу жилд 2 удаа зохион байгуулж үр дүнгээр нь тайлан хэвлүүлсэн.
- Хөтөлбөрийн дэд хороо, багш нарт танилцуулах ажлыг 7 ба 1 сард зохион байгуулдаг.
- Сүүлийн 5 жилийн байдлаар 32 төгсөгч ахисан түвшний сургалтанд хамрагдсан нь төгссөн оюутны тоотой харьцуулахад харьцангуй их гэж үзэж болно.
- Төгсөгчдийн амжилт, бүтээлийг сэтгүүл, албан ёсны сайт, номонд нийтлэхээс гадна тусгай нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд таниулдаг.
- Төгсөгчдөөс нийт 12 төгсөгч Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч, татварын мэргэшсэн зөвлөх, хөрөнгийн үнэлгээчин болжээ.
- Төгсөгчид ажилд орох хугацаа дунджаар 6 сар буюу ажилд ороход хүлээх хугацаа бага байна.
- Төгсөгчдөөс авах судалгаанд нийт төгсөгчдийн 10 хувиас доошгүй хувийг хамруулдаг.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн 29 хувь нь эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж байгаа тул цаашид ажил олгогчид, төгсөгчдөөс авсан судалгаанд тулгуурлан хөтөлбөрт тасралтгүй сайжруулалтыг хийх

Зөвлөмж:

- Төгсөгчдөд сургууль төгссөний дараа тэдний эрэлт, хэрэгцээнд нийцсэн богино хугацааны сургалтыг зохион байгуулах боломжийг эрэлхийлэх

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Байгууллагын магадлан итгэмжлэлийн сертификат
- ACBSP олон улсын магадлан итгэмжлэлийн сертификат
- Нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрийг БМИҮЗ-өөр магадлан итгэмжлүүлсэн сертификат
- Green Universities Partnership of Environment and Sustainability (GUPES)-ийн гишүүнээр элссэн сертификат
- Thomas Philip, Тайваны Мин Чуаны их сургууль, АНУ-ын iGlobal их сургууль, Шведийн Уппсалагийн их сургууль, БНХАУ-ын Ляониний их сургууль, БНСУ-ын Конгжу Үндэсний их сургууль, БНСУ-ын Олон улсын их сургууль, Белгийн Гентийн их сургуулиудтай байгуулсан санамж бичгийн хуулбар

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ОТИС нь Байгууллагын магадлан итгэмжлэлээр 3 дахь удаагаа магадлан итгэмжлэгдсэн.
- ЭЗБУС нь 2013 оноос Бизнесийн сургуулиуд, сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн зөвлөл (ACBSP)-ийн шалгуур шаардлагыг ханган ажиллаж үйл ажиллагаагаандаа өөрийн үнэлгээ хийж 2017 оны 5-р сард олон улсад магадлан итгэмжлүүлсэн.
- Нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрийг 2014 онд Үндэсний магадлан итгэмжлэлийн байгууллага БМИҮЗ-өөр магадлан итгэмжлүүлсэн.
- Гадаадын их сургуулиуд, мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан.
- Европын Холбооны санхүүжилтээр Erasmus+ төсөл хэрэгжүүлдэг. 2018 онд НҮБ-ийн Green Universities Partnership of Environment and Sustainability (GUPES)-ийн албан ёсны гишүүнээр элссэн.
- 2019 оны байдлаар ОТИС-ын Эдийн засаг, бизнесийн удирдлагын сургууль нь Малайз улсад “Thomas Philip” хууль зүйн фирмтэй хамтран багш, оюутан солилцон дадлагажуулах хөтөлбөр, Тайваны Мин Чуаны их сургууль, АНУ-ын iGlobal их сургуулиудтай оюутан солилцох болон бусад хөтөлбөрүүдийг, Шведийн Уппсалагийн их сургууль, БНХАУ-ын Ляониний их сургууль, БНСУ-ын Конгжу Үндэсний их сургууль, БНСУ-ын Олон улсын их сургууль, Белгийн Гентийн их сургуулиудтай хамтран “Тогтвортой хөгжлийн боловсрол” төслийг хэрэгжүүлэх чиглэлд хамтран ажиллаж байна.
- Их дээд сургуулиудын консорциум, МУИС-БС, ХААИС-ЭЗБС, СЭЗИС, МИС, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Монголын менежментийн холбоо, Банк санхүүгийн академи, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт, Хүний нөөц соёмбо академи, Монголын бэлчээрийн менежмент- Ногоон алт, БЗД-ийн нийгмийн даатгалын хэлтэс, БЗД-ийн татварын хэлтэс зэрэг төрийн байгууллага, их сургуулиуд, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллажээ.

Анхаарах асуудал:

- НББ-ын Улсын олимпиадад оюутнуудыг тусгайлан бэлтгэж оролцуулж амжилт гаргах замаар хөтөлбөрийн нэр хүндийг өсгөх

Зөвлөмж:

- ОТИС-ийн хэмжээний хамтын ажиллагаатай их, дээд сургуулиудын оюутан солилцооны хөтөлбөрт НББ-ын ангийн оюутнуудын хамрагдах тоог нэмэгдүүлэх

7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**ДҮГНЭЛТ**

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Хангаагүй үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2	Сургалтын үйл ажиллагаа	2			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
6	Багшийн үйл ажиллагаа	2			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			
Нэгдсэн үнэлгээ		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Отгонтэнгэр их сургуулийн Эдийн засаг, бизнесийн удирдлагын сургуулийн “Нягтлан бодох бүртгэл” бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуурт нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Бизнесийн удирдлага чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг Л.Энх-Амгалан

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....Н.Нямаа

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....М.Уранчимэг

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

1. Төсөл, хөтөлбөрт оролцдог туршлагатай багш нар залуу багш нарыг судалгааны ажилдаа оролцуулах, тэднийг судалгаа хийхэд дэмжлэг үзүүлэх
2. Доктор зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлэх
3. Мэргэшсэн нягтлан бодогч зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлэх
4. Багш нарын англи хэлний мэдлэгийг гадаад улсад мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх түвшинд хүргэх
5. Багш нарыг гадаад улсын их, дээд сургуулиудын онлайн сургалтанд хамруулах
6. Багш нар багаараа хамтарч судалгааны ажлын санал бичиж захиалагч талд хүргүүлэх зэрэг судалгааны ажил гүйцэтгэхэд санаачлагатай байх
7. Багш нарын судалгааны ажилд зориулсан санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх
8. Багш нарын гадаад, дотоодын өндөр чансаатай сэтгүүлд бүтээлээ нийтлүүлэхэд шинжлэх ухааны өөр салбарын багш нартай хамтарч ажиллахад дэмжлэг үзүүлэх
9. Багш нарын үндсэн ажлын цалингаас гадна судалгаа шинжилгээний ажлаас нэмэлт орлого олох боломжийг нээх үүднээс сургуулийн захиргаанаас шаардлагатай мэдээллээр байнга хангаж байх
10. Төгсөгчдөд сургууль төгссөний дараа тэдний эрэлт, хэрэгцээнд нийцсэн богино хугацааны сургалтыг зохион байгуулах боломжийг эрэлхийлэх
11. ОТИС-ийн хэмжээний хамтын ажиллагаатай их, дээд сургуулиудын оюутан солилцооны хөтөлбөрт НББ-ын ангийн оюутнуудын хамрагдах тоог нэмэгдүүлэх

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

- I. Багш нарын төлөөлөлтэй хийсэн уулзалтын бүртгэл

№	Овог нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилл асан жил	Заадаг хичээл	Утас	Имэйл хаяг
1	У.Золзаяа	Багш	магистр	2	Хүний хөгжил, Улс төр судлал	80036333	Zolzaya@otgontenger.edu.mn
2	Г.Жаргалсайхан	Дэд проф	доктор	14	Монголын түүх ёс заншил	99731975	jargalsaikhan@otgontenger.edu.mn
3	Ц.Өлзийхишиг	Ахлах багш	магистр	16	Гадаад хэл	88099516	ulziikhishig@otgontenger.edu.mn
4	Б.Мөнхсүлд	Багш	магистр	12	Биеийн тамир эрүүл мэнд	90990205	munkhsuld@otgontenger.edu.mn
5	С.Одхүү	Дэд проф	доктор	6	Харилцааны ёс зүй	99184136	Odkhuu@otgontenger.edu.mn
6	Б.Энхбаяр	Ахлах багш	магистр	15	Бизнесийн ёс зүй	99077980	enkhbayar@otgontenger.edu.mn
7	Н.Мөнхзул	Ахлах багш	магистр	12	эконометрик	88082273	munkhsul@otgontenger.edu.mn
8	А.Ганзориг	Ахлах багш	магистр	14	НББ	88051131	ganzorig@otgontenger.edu.mn
9	С.Баярцогт	Ахлах багш	магистр	14	НББ, татвар	88075534	bayartsoqt@otgontenger.edu.mn
10	А.Батмандах	Ахлах багш	магистр	14	математик	88099868	batmandakh@otgontenger.edu.mn
11	Д.Мөнхбаатар	Ахлах багш	магистр	14	Мэдээллийн технологи, мэдээллийн систем	88170165	munkhbaatar@otgontenger.edu.mn
12	Л.Удвал	Дэд проф	Магистр, МНБ	21	НББ, Аудит, татвар	88073645	Uugii_lu@yahoo.com
13	П.Эрдэнэчимэг	Ахлах багш	магистр	13	НББ	88020800	p.erdenechimeg@otgontenger.edu.mn
14	М.Довууч	Ахлах багш	доктор	17	Санхүү менежмент	96051262	dovuuch@otgontenger.edu.mn
15	Ж.Ганзаяа	БПХТ-ийн эрхлэгч	магистр	14	Бүртгэлийн мэдээллийн үндэс	96015767	ganzaya@otgontenger.edu.mn
16	Н.Отгонбаяр	БУТ-ийн эрхлэгч	доктор	12	Хүний нөөц	88051557	otgonbayar@otgontenger.edu.mn
17	Ө.Амгалан	Ахлах багш	магистр	19	Маркетингийн менежмент	96663387	amgalan@otgontenger.edu.mn

II. Оюутны төлөөлөлтэй хийсэн цахим уулзалтын бүртгэл

Оюутны төлөөллийг сонгох-15 орчим. /курс, оюутны байранд амьдардаг орон нутгийн оюутан, хөгжлийн бэрхшээлтэй оюутан, гадаад, оюутны сайн дурын байгууллагын гишүүн, голч дүн гэх мэтээр төлөөллийг сонгов/

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас	Имэйл хаяг
1.	Г.Сувд	4	УБ	89520107	Gansuh.suvd@gmail.com
2.	Б.Болдбаатар	4	УБ	90211818	ch.boldoo12@gmail.com

3.	Э.Ганзул	4	Орон нутаг	96698785	ganzul08@gmail.com
4.	Ц.Номундарь	4	Орон нутаг	86172224	nomuk59@gmail.com
5.	Т.Золцэцэг	4	УБ	89981820	T.Zoltsetseg03@gmail.com
6.	В.Мядагбадам	2	Орон нутаг	80050258	V.Mara0308gmail.com
7.	Б.Дэлгэрханд	2	Дотуур байр	99569226	Delgerkhand@gmail.com
8.	Э.Пүрэвсүрэн	2	Орон нутаг	99846382	Purevsuren9984@gmail.com
9.	Д.Нямгэрэл	2	Орон нутаг	80136482	Ngerlee0923@gmail.com
10.	Цэцэглэн	3	Орон нутаг	88845966	altanhuygtsetseglen21@gmail.com
11.	Д.Должинсүрэн	3	Орон нутаг	88474386	dorjderemdoljinsuren@gmail.com
12.	Ц.Дашбат	3	Дотуур байр	80660462	dashbat2121@gmail.com
13.	А.Амаржаргал	3	Орон нутаг	80065852	aagiiamra8@gmail.com
14.	Т.Мөнхзул	4	УБ	88099683	munkhzul11111@gmail.com
15.	А.Сарнай	3	УБ	88051920	a.sarnai.as@gmail.com

III. Төгсөгчдийн төлөөлөлтэй хийсэн цахим уулзалтын бүртгэл

Төгсөгчдийн төлөөллийг сонгох-15 орчим хүн /Сүүлийн 5 жилийн, он, оны төлөөлөл, төрийн болон бусад байгууллагад ажиллаж байгаа гэх мэт/

№	Овог нэрс	Төгссөн он	Ажилладаг байгууллага	Албан тушаал	Утас
1.	Ц.Батдэлгэр	2005	СХД-ийн Хөдөлмөр халамжийн хэлтэсийн	Хүнс тэжээл, дэмжлэг туслалцаа хариуцсан мэргэжилтэн	99031291
2.	Б.Цэрэнчомбо	2005	АПУ ХК-д	Ахлах нягтлан бодогч	99081684
3.	Т.Мягмарсүрэн	2005	Статистикийн төв хороо	Мэргэжилтэн	99068383
4.	Ц.Жаргалмаа	2005	ХАС банкинд	Харилцааны менежер	99048395
5.	Г.Гандаваа	2017	БИМЕКС холдинг	Ахлах нягтлан бодогч	99036175
6.	Б.Баасанбат	2017	МОНОС ХХК-д	Нягтлан бодогч	99569222
7.	О.Амгаланбаатар	2007	Монгол Францын төв	Нягтлан бодогч	91921986
8.	З.Эрдэнэбулган	2007	ТЭМСО	Худалдан авах ажиллагааны менежер	99051592
9.	Б.Болоргэрэл	2007	"Мон тахь тэх" ХХК-д	Нягтлан бодогч	89018673

10.	А.Кунсулу	2018	Мон экс файненс ХХК	ахлах нягтлан бодогч	89107700
11.	Н.Энхбаяр	2009	Нийслэлийн газрын алба	нягтлан бодогч	95752977
12.	Ү.Болормаа	2009	Мастер проперти Менежмент ХХК	Ерөнхий нягтлан бодогч	99996248
13.	М.Мөнххайрхан	2015	УБТЗ-ын удирдах газар	Хатуу тооцоот бланк складны эрхлэгч	88668484
14.	Б.Номин	2018	Люксолюшн ХХК	Ерөнхий нягтлан бодогч	88555877
15.	Ц.Отгонбаатар	2008	Хууль сахиулах ДС-ийн Санхүүгийн хяналт	Шалгалтын мэргэжилтэн	99600543
16.	Ц.Ишдорж	2012	АШУҮИС	Нягтлан бодогч	99131680
17.	Б.Цэцэгтуяа	2017	Баясах өргөө ХХК	Ахлах нягтлан бодогч	88041766

IV. Ажил олгогчдын төлөөлөлтэй хийсэн цахим уулзалтын бүртгэл

№	Овог нэр	Байгууллагын нэр албан тушаал	Холбоо барих утасны дугаар	Мэйл хаяг
1.	Н.Цэнгэл	Эрдэнэс таван толгой ХК /Хүний нөөц, сургалт судалгаа хариуцсан менежер	99101864	Tsengel15161728@gmail.com
2.	С.Халиун	Татварын ерөнхий газар /Хүний нөөцийн мэргэжилтэн	96091192	Khaliun.ch@mta.mn
3.	Д.Алтанцэцэг	"FL Smidth" ХХК-ний Ерөнхий нягтлан бодогч	80081535	Aagii8325@gmail.com
4.	Б.Чулуунцэцэг	Таван богд Фүүдс ХХК-ны Ерөнхий нягтлан бодогч	99994009	Chuka_chups@yahoo.com
5.	А.Анхчимэг	ХААН банкны ахлах харилцааны менежер	99089451	Ankhaa_005@yahoo.com Ankhchimeg.a@khanbank.com
6.	Д.Батсүх	Үндэсний статистийн төв газрын Санхүүгийн албаны дарга	99082959	Batsukh_d@nso.mn
7.	Х.Хосцэцэг	Автофикс ХХК-ны захирал	94103103	Mhosoo@yahoo.com
8.	А.Чинзориг	БЗД-н НДХэлтсийн байцаагч	80087177	Chinzorig.a@ndaatgal.mn
9.	С.Алтанцэцэг	Голомт банкны салбарын захирал	99008586	Altaa.samdan@gmail.com
10.	С.Түвшинтөр	МонЭкс Финанс ХХК захирал	88112174	Turuu0302gmail.com
11.	Э.Баярцэцэг	Актив энерги зон ХХК Ерөнхий нягтлан бодогч	80166023	Bayartsetseg.e0710@gmail.com
12.	Ш.Отгонжаргал	Өсвөр үе ОНӨААТҮГ газар Ерөнхий нягтлан бодогч	99032959	Otgongjargalsh2015@gmail.com
13.	Д.Болорцэцэг	УБ Банк Байгууллагын банкны газар харилцагчийн менежер	99236168	Bolortsetseg@ubcbank.mn
14.	Ц.Төгсжаргал	Монбурда ХХК захирал	99071309	Chimegee1309@gmail.com
15.	Н.Адьяасүрэн	Баясах өргөө ХХК ерөнхий нягтлан	88042569	Adika_0319@yahoo.com adiyasuren@bayasakh.mn
16.	Д.Мэнджаргал	Wuerthmongolia ХХК санхүү эрхэлсэн дэд захирал	99994297	mendjargal@wuerthmongolia.com

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/